



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 16

Зуунмод сум

Ажил эрчимжүүлэх тухай

Төрийн албаны хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар төрийн байгууллагуудын захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаанд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах ажлыг удирдамжийн дагуу 4 агентлаг, 14 суманд зохион байгуулсан бөгөөд ажлын хэсгүүдээс ирүүлсэн илтгэх хуудас, дүгнэлтийг харгалзан Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1.1, 3.1.3, 3.1.5, 3.6.3, 3.6.4 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган албан хаагчдад чиглэсэн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, ёс зүйн болон сахилгын зөрчилгүй ажиллуулах зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

1.1. Төрийн албаны тухай хуулийн 27.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган сул орон тооны мэдээллийг олон нийтэд мэдээлж, хуульд заасан хугацаанд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг ирүүлэх;

1.2. Төрийн жинхэнэ албаны сул орон тоонд түр орлон гүйцэтгэгч томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан журмыг чанд мөрдөх;

1.3. Хүний нөөцийн чиглэлээр гаргаж буй тушаал, шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг сайтар судлан оновчтой хэрэглэх;

1.4. Төрийн албаны тухай хуулийн 55.3, 61, 62 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, аймгийн түвшинд хэрэгжүүлэхээр гаргасан бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг судалгаа шинжилгээний үндэслэлтэй, төсвийн тооцоотой боловсруулан баталж, хэрэгжүүлэх;

1.5. Төрийн албаны тухай хуулийн 55.3 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 04 дүгээр зөвлөмж, Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар тогтоол зэрэг шийдвэрүүдтэй уялдуулан “Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг судалгаа шинжилгээний үндэслэлтэй, төсвийн тооцоотой боловсруулан баталж, албан хаагч бүрт сургалтын карт хөтлөх замаар хэрэгжүүлэх;

1.6. Төрийн албан хаагч бүрийн ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитой үнэлж, дүгнэн урамшуулал, хариуцлагыг тооцож хэвших. (Төсвийн шууд захирагчийн

ажлыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлыг тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн улс төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлыг тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр дүгнэх);

1.7. Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг байгууллагын удирдлага, хамт олон, хэрэглэгчийн үнэлгээгээр дүгнэж хэвших;

1.8. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан ажиллах журмыг баталж, тухайн жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг байх;

1.9. Ажлын болон ажлын бус цагаар, ажлын байранд болон бусад олон нийтийн газарт төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн зан харилцааны доголдол гаргахгүй байх;

1.10. Дээд шатны байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу бүх албан тушаалын тодорхойлолтуудыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулах;

1.11. Төрийн албан хаагчийг тухайн албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийн дагуу ажиллуулах;

1.12. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системийн баяжилтыг төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тулгуурлан бүрэн гүйцэт, үнэн зөв оруулж, төрийн албаны цалингийн системтэй холбон мэдээллийн зөрүү үүсгэхгүй байх;

2. Дээр дурьдсан арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд гаргаж, хэрэгжилтийн явцыг 2021 оны 10 дугаар сарын 29, биелэлтийг 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг сум, хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Мөнхгэрэл)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.МАГНАЙБАЯР